



**ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ
СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2020 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 1/194

Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27¹.1.1, 27¹.1.6 дахь хэсэг, “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн дүрэм”-ийн 10 дугаар зүйлийн 10.11.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 11 сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоол, компанийн 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн өргөтгөсөн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улс орны хэмжээнд бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотой компанийн төв удирдлагын ажилтнуудын биеийн байдалд хяналт тавих, халуун хэмжих, цаг ашиглалтыг хянах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй зохион байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Мөнхзаяа /Хяналт мониторингийн хэлтсийн ахлах бөгөөд техник хяналтын инженер/
Нарийн бичгийн дарга: Н.Эрдэнэжаргал /Хяналт мониторингийн хэлтсийн техник хяналтын инженер/
Гишүүд: Э.Ууганцэцэг /Хяналт мониторингийн хэлтсийн хүний их эмч/
Г.Алтангэрэл /Захиргаа удирдлагын хэлтсийн хуулийн зөвлөх/
Б.Ганцэцэг /Санхүү, эдийн засгийн хэлтсийн ахлах эдийн засагч/
Д.Авирмэд /Нийтлэг үйлчилгээ, тээвэр механизмын хэлтсийн цайны газрын зохион байгуулагч/

2. Компанийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотой ажилтнуудын биеийн байдлыг хянаж, халууныг хэмжих, цаг ашиглалт, гэрээс ажиллаж байгаа ажилтнуудын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, албан болон хувийн тээврийн хэрэгслийн маршрутад хяналт тавих, уртасгасан цагаар ажилласан ажилтнуудын судалгааг гаргаж, холбогдох мэдээллийг компанийн хэмжээнд нэгтгэн удирдлага болон хариуцлагатай жижүүрт 2 цаг тутамд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Мөнхзаяа/-д, салбарт ажлын хэсэг томилж, ажилтнуудын биеийн байдлыг хянаж, халууныг хэмжих, цаг ашиглалт, гэрээс ажиллаж байгаа ажилтнуудын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, албан болон хувийн тээврийн хэрэгслийн маршрутад хяналт тавих, уртасгасан цагаар ажилласан ажилтнуудын судалгааг гаргаж, холбогдох мэдээллийг ажлын хэсгийн ахлагч /Д.Мөнхзаяа/-д, 2 цаг тутамд тайлагнаж ажиллахыг салбаруудын дарга нарт үүрэг болгосугай.

171201515

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг компанийн тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер /Б.Дашдаваа/-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *Джам* Б.НЯМСАМБУУ

